



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 04/37

Мандалговь

“Хэрмээдэй” ХХК-тай гэрээ байгуулах тухай


Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 34 дугаар зүйлийн 30.4.3, 34.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх “Соёлын төвийн барилга, 240 суудалтай, (Дундговь, Цагаандэлгэр)” ажлын гүйцэтгэгчээр “Хэрмээдэй” ХХК-ийг сонгон 1,228,346,087 (нэг тэрбум хоёр зуун хорин найман сая гурван зуун дөчин зургаан мянга наян долоо) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Соёлын төвийн барилга, 240 суудалтай, (Дундговь, Цагаандэлгэр)” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Хэрмээдэй” ХХК-ны захирал (Ц.Мандах)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Цагаандэлгэр сумын Засаг дарга (Д.Буджав), Цагаандэлгэр сумын Соёлын төвийн эрхлэгч (Б.Алдармаа), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060204